

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аймгийн Нийгмийн даатгалын төсвийн төвлөрүүлэн захирагчийн

2017 оны 12 дугаар сарын 31-нээр

дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан

Аудитын код: БӨА-2018/15/СТА-ТТЗ

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.2, Төрийн аудитын тухай хуулийн 15.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дах Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Аймгийн Нийгмийн даатгалын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аймгийн Нийгмийн даатгалын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аймгийн Нийгмийн даатгалын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 3 дугаар сарын 05-наас 2018 оны 3 дугаар сарын 11-ний хооронд хийхээр төлөвлөн Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газрын аудитор Д.Назгүл хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Аймгийн Нийгмийн даатгалын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 санхүүгийн тайланг 2018 оны 01 дүгээр сарын 26-нд аймаг дах Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 3 дугаар сарын 05-наас 2018 оны 3 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 12-нд Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Аймгийн Нийгмийн даатгалын төсвийн төвлөрүүлэн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль,

Тэтгэврийн даатгалын шимэтгэлийн нэрийн дансны тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тухай хууль, Мэдээллийн технологи программ хангамжийн тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зэрэг хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт томоохон өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Байгууллагын зорилго нь: “Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтөх, нийгмийн даатгалын шимтгэл төлүүлэх, санг бүрдүүлэх, зарцуулах болон нийгмийн даатгалын хууль, журам, тогтоол, шийдвэрүүдийг хэрэгжүүлэх”

Зорилт нь: Даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх” гэж заасны дагуу аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Аймгийн Нийгмийн даатгалын 2017 оны төсвийг Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газрын төсвийн багц, тэтгэмжийн сангуудын шимтгэлийн орлогоос санхүүжүүлэн аймгийн Төрийн сан болон аймаг дахь арилжааны банкуудаар дамжуулан олгосон байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай багц хуулиудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аймгийн Нийгмийн даатгалын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар аймгийн Нийгмийн даатгалын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл

болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 18-ийг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаанд УНДЕГ-аас баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ажилласан байна. Энэхүү бодлогын баримт бичиг нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүй болон УСНББОУС-тай нийцсэн байна.

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа программын үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Ниймийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг НДЕГ-ын дэргэдэх МТТ-ийн гаргасан Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэл программаар хөтөлдөг. Уг программаар гарсан тайлангуудыг хөрвүүлж “Пластик” програмаар нэгтгэдэг. Дотоод санхүүжилт, төвлөрүүлэлтүүдийг сангийн данс руу хааж тохируулдаг.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг МТТ-ийн NEGТ программаар гаргадаг. Энэ программаар шимтгэлийн орлогын хувиарлалтыг ногдуулалтаар нь тохируулан, санхүүжилт, төвлөрүүлэлтүүдийг цэвэрлэж нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргадаг.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Аймгийн Нийгмийн даатгалын төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу УНДЕГ-аас аймгийн төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Аймгийн Нийгмийн даатгалын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2017 онд 52985,8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 52906,0 сая төгрөгийн санхүүжилт авч, батлагдсан төсвөө 79,8 сая төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

Үүнийг задалж авч үзвэл: Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас 205,7 сая төгрөгийн хэмнэлттэй ба “Элэг бүтэн монгол” хөтөлбөрийн хүрээнд урьдчилан сэргийлэх вакцины зардал болон эрт илрүүлэх шинжилгээний зардлаас зарцуулагдаагүй үлдсэнтэй холбоотой.

Эмийн сангийн нийт төсвөөс элэгний С вирусын эмийн зардалд батлагдсан төсвөөс 60,5 сая төгрөг зарцуулагдаагүй байна.

Мөн Засгийн газрын дотоод шилжүүлэг буюу Нэгдсэн эмнэлэгт олгосон санхүүжилт 42,3 сая төгрөгөөр илүү гүйцэтгэлтэй харагдаж байгаа нь төлөвлөгөө нь “Элэг бүтэн монгол” хөтөлбөрийн хүрээнд хувийн хэвшлийн байгууллагад олгох төсөвт тусгагдсантай холбоотой байна.

Тэтгэвэр, тэтгэмжид олгосон шилжүүлэг 87,1 сая төгрөгөөр хэтэрсэн дүнтэй байна. Үүний шалтгаан нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн өөрчлөлтийн дагуу цэргийн тэтгэвэр авагчид нэг удаа тэтгэвэр тогтоолгосон цалингаа өөрчилж, тэтгэврийг дахин өсгөн тогтоолгосонтой холбоотой байна.

Тайлант оны Төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх орлогын гүйцэтгэлийг батлагдсан төлөвлөгөө, өмнөх жилүүдийн үзүүлэлтүүдтэй харьцуулж шинжилгээ хийж, орлогын төлөвлөгөөний биелэлтийг тодруулав.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангаж ажиллах зорилгоор shilendans.gov.mn цахим хуудсанд 2017 оны мэдээлэлээ бүрэн байршуулжээ.

2017 онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитаар алдаа, зөрчил илэрээгүй байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 18 нарийвчилсан болон хяналтын горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Аймгийн Нийгмийн даатгалын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний орлого-санхүүжилт, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, авлага, өглөгийн дансуудад хяналтын горим, сорил гүйцэтгэж, тайланд нэгтгэсэн байгууллагуудын тайланг нэгтгэж нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил илэрээгүй.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдаагүй алдаа зөрчил гараагүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Аймгийн Нийгмийн даатгалын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн аудитаар алдаа зөрчил илэрээгүй ба аймгийн Нийгмийн даатгалын сангийн Төсвийн шууд захирагчийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг тайланд дурьдвал:

1.Түүвэр сорил хийж үзсэн баримтуудаас ажилгүйдлийн тэтгэмжтэй холбоотой 9,6 сая төгрөгийн 15 ш, ҮОМШӨД Сангийн гүйлгээтэй холбоотой 24,0 сая төгрөгийн 9, Тэтгэмжийн даатгалын сангийн орлого ба зарцуулалтаар 21,2 сая төгрөгийн 11 бүгд 54,8 сая 35 ажил гүйлгээний анхан шатны баримтыг дутуу бүрдүүлж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6, 13.7, 14.3.1 дэхь заалтуудыг заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2. Тайлант онд байгууллагуудаас авах авлага өмнөх оны дунджаас 101,8 сая төгрөгөөр, татаас санхүүжилтийн авлага 410,0 сая төгрөгөөр, бусад зардлын тооцооны авлага 3,6 сая төгрөгөөр буюу авлагын үлдэгдэл өмнөх оноос 515,5 сая төгрөгөөр нэмэгдэж нийтдээ 846.0 сая төгрөгийн авлагтай гарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалттай нийцэхгүй байна.

Илэрсэн алдаа, зөрчлийн дүнгээр: -Санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлтийг бүрэн хангаж, авлагыг бүрэн барагдуулж ажиллахыг менежментийн захидлаар зөвлөмж өгөгдсөн.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Аймгийн Нийгмийн даатгалын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан, менежементийн захидал ... хуудас хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН
Огноо:2018.03.12

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК
Огноо:2018.03.12

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Д.НАЗГҮЛ
Огноо:2018.03.12